

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/007/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: baranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2026.02.10 № 02

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Т.БАЯСГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4226050037

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,200,882.00	5,362,577.00
33	АВЛАГА	2.00	2.00
33500	Бусад авлага	2.00	2.00
33510	Байгууллагаас авах авлага	2.00	2.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,200,880.00	5,362,575.00
35400	Хангамжийн материал	8,200,880.00	5,362,575.00
35410	Бичиг хэргийн материал	394,000.00	75,000.00
35420	Аж ахуйн материал	5,126,650.00	4,957,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,594,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	1,086,230.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	330,125.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	733,100,943.97	755,904,971.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	733,100,943.97	755,904,971.48
39200	Биет хөрөнгө	709,031,943.97	723,085,971.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	812,475,675.68	812,475,675.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-148,090,235.11	-163,400,800.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	8,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,000,000.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	73,506,851.38	93,148,745.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,830,563.56	-33,209,370.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,742,910.00	23,551,874.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,772,694.42	-17,680,152.40
39300	Биет бус хөрөнгө	24,069,000.00	32,819,000.00
39301	Программ хангамж	0.00	9,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,069,000.00	24,069,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	741,301,825.97	761,267,548.48
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,641,908.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,641,908.92
41300	Өглөг	0.00	1,641,908.92
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	1,641,908.92
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	741,301,825.97	759,625,639.56
51	Засгийн газрын хувь оролцоо	741,301,825.97	759,625,639.56
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,010,138.98	150,010,138.98
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	150,010,138.98	150,010,138.98

51200	Хуримтлагдсан үр дүн	483,812,548.94	502,136,362.53
51210	Өмнөх үеийн үр дүн	483,812,548.94	483,812,548.94
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	18,323,813.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,479,138.05	107,479,138.05
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	741,301,825.97	761,267,548.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	744,530,459.40	915,093,620.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,423,080.00	48,201,419.08
120	Нийтлэг татварын бус орлого	2,423,080.00	48,201,419.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,423,080.00	48,201,419.08
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,751,280.00	47,796,339.08
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	671,800.00	405,080.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,107,379.40	866,892,201.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,707,679.40	50,789,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,638,879.40	50,789,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,800.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	705,399,700.00	816,102,401.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	705,399,700.00	816,102,401.00
135	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	760,121,734.87	896,769,806.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,121,734.87	896,769,806.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	618,953,117.84	709,540,735.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,504,684.55	544,926,812.37
210101	Үндсэн цалин	244,691,567.88	292,185,070.64
210102	Нэмэгдэл	137,035,048.49	175,553,019.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,083,400.30	34,302,611.11
210104	Урамшуулал	44,694,667.88	42,886,111.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,198,432.75	62,954,571.69
210201	Тэтгэврийн даатгал	37,742,010.13	42,546,361.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,486,791.79	5,482,753.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,231,753.92	2,703,509.46
210204	Ажилгүйдлийн даатгал	2,115,620.93	2,421,765.61
210205	Эрүүл мэндийн даатгал	8,622,255.98	9,800,180.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,123,944.42	52,022,998.05
210301	Гэрэл, цахилгаан	3,937,566.42	5,904,648.05

210302	Түлш, халаалт	41,912,640.00	44,906,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,273,738.00	1,211,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,527,665.65	11,365,280.00
210401	Бичиг хэрэг	6,422,000.00	3,351,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,713,770.00	1,086,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,094,245.65	2,391,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,057,650.00	4,296,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,774,000.00	344,000.00
210604	Урсгал засвар	13,774,000.00	344,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,734,800.00	2,210,000.00
210702	Дотоод албан томилолт	4,734,800.00	2,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	954,807.00	799,762.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	434,250.00	449,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,100.00	32,382.00
210807	Газрын төлбөр	24,957.00	23,625.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	139,700.00	219,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	276,800.00	74,955.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,134,783.47	34,917,311.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	930,000.00	430,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,204,783.47	34,487,311.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,168,617.03	187,229,070.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,871,852.00	41,982,385.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,736,000.00	1,696,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	31,313,385.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,135,852.00	8,973,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108,296,765.03	145,246,685.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,296,765.03	145,114,415.04
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	132,270.77
2232	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	-15,591,275.47	18,323,813.59
228	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-15,591,275.47	18,323,813.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	742,107,379.40	866,892,201.00
1.3	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,107,379.40	866,892,201.00
1.3.2	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,707,679.40	50,789,800.00
1.3.2.3	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,638,879.40	50,789,800.00
1.3.2.4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,800.00	0.00
1.3.4	Төсвийн захирагчдаас	705,399,700.00	816,102,401.00
1.3.4.1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	705,399,700.00	816,102,401.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	728,732,379.40	857,397,201.00
2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	728,732,379.40	857,397,201.00
2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,563,762.37	670,869,369.06
2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,504,682.55	544,926,812.37
2.1.1.1.1	Үндсэн цалин	244,691,565.88	292,185,070.64
2.1.1.1.2	Нэмэгдэл	137,035,048.49	175,553,019.02
2.1.1.1.3	Унаа хоолны хөнгөлөлт	24,083,400.30	34,302,611.11
2.1.1.1.4	Урамшуулал	44,694,667.88	42,886,111.60
2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,198,432.75	62,954,571.69
2.1.1.2.1	Тэтгэврийн даатгал	37,742,010.13	42,546,361.80
2.1.1.2.2	Тэтгэмжийн даатгал	4,486,791.79	5,482,753.92
2.1.1.2.3	ҮОМШӨ-ний даатгал	2,231,753.92	2,703,509.46
2.1.1.2.4	Ажилгүйдлийн даатгал	2,115,620.93	2,421,765.61
2.1.1.2.5	Эрүүл мэндийн даатгал	8,622,255.98	9,800,180.90
2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,123,944.42	51,984,650.00
2.1.1.3.1	Гэрэл, цахилгаан	3,937,566.42	5,866,300.00
2.1.1.3.2	Түлш, халаалт	41,912,640.00	44,906,400.00
2.1.1.3.3	Цэвэр, бохир ус	1,273,738.00	1,211,950.00
2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	14,619,895.65	7,294,528.00
2.1.1.4.1	Бичиг хэрэг	6,456,000.00	2,595,900.00
2.1.1.4.2	Тээвэр, шатахуун	2,500,000.00	0.00
2.1.1.4.3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,094,245.65	1,957,128.00
2.1.1.4.5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	208,000.00
2.1.1.4.6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,329,650.00	2,533,500.00
2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	13,774,000.00	344,000.00
2.1.1.6.4	Урсгал засвар	13,774,000.00	344,000.00
2.1.1.7	Томилолт, зочны зардал	4,734,800.00	2,210,000.00
2.1.1.7.2	Дотоод албан томилолт	4,734,800.00	2,210,000.00

2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	678,007.00	724,807.00
2.1.1.8.1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,000.00	0.00
2.1.1.8.3	Даатгалын үйлчилгээ	434,250.00	449,100.00
2.1.1.8.4	Тээврийн хэрэгслийн татвар	27,100.00	32,382.00
2.1.1.8.7	Газрын төлбөр	24,957.00	23,625.00
2.1.1.8.8	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	139,700.00	219,700.00
2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	930,000.00	430,000.00
2.1.1.9.2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	930,000.00	430,000.00
2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,168,617.03	186,527,831.94
2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	32,871,852.00	41,281,146.13
2.1.4.2.3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,736,000.00	1,696,000.00
2.1.4.2.6	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	31,110,046.13
2.1.4.2.7	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,135,852.00	8,475,100.00
2.1.4.3	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108,296,765.03	145,246,685.81
2.1.4.3.2	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,296,765.03	145,114,415.04
2.1.4.3.5	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	132,270.77
2.2	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,375,000.00	9,495,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	13,375,000.00	9,495,000.00
4.1	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,375,000.00	9,495,000.00
4.1.1	Дотоод эх үүсвэрээр	13,375,000.00	9,495,000.00
4.1.1.6	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,375,000.00	9,495,000.00
4.2.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-13,375,000.00	-9,495,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	499,403,824.48		756,893,101.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-0.07		-0.07
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	499,403,824.41		756,893,101.44
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00		0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00		0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00		0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-15,591,275.47		-15,591,275.47
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	483,812,548.94		741,301,825.97
11	2025 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	483,812,548.94		741,301,825.97
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	483,812,548.94		741,301,825.97
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00		0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00		0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00		0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	18,323,813.59		18,323,813.59
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	502,136,362.53		759,625,639.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	828,319,200.00	670,987,985.96	157,331,214.04	81.00%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	828,319,200.00	670,987,985.96	157,331,214.04	81.00%
2.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,011,700.00	629,706,839.83	157,304,860.17	80.00%
2.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,106,400.00	499,482,145.17	111,624,254.83	82.00%
2.1.1.1	Үндсэн цалин	310,632,500.00	292,185,070.64	18,447,429.36	94.00%
2.1.1.2	Нэмэгдэл	170,728,800.00	130,108,351.82	40,620,448.18	76.00%
2.1.1.3	Унаа хоолны хөнгөлөлт	43,483,500.00	34,302,611.11	9,180,888.89	79.00%
2.1.1.4	Урамшуулал	86,261,600.00	42,886,111.60	43,375,488.40	50.00%
2.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,770,400.00	57,741,709.66	19,028,690.34	75.00%
2.1.2.1	Тэтгэврийн даатгал	52,199,800.00	39,044,986.20	13,154,813.80	75.00%
2.1.2.2	Тэтгэмжийн даатгал	6,153,200.00	5,028,307.24	1,124,892.76	82.00%
2.1.2.3	ҮОМШӨ-ний даатгал	3,074,900.00	2,476,286.10	598,613.90	81.00%
2.1.2.4	Ажилгүйдлийн даатгал	3,068,000.00	2,215,802.32	852,197.68	72.00%
2.1.2.5	Эрүүл мэндийн даатгал	12,274,500.00	8,976,327.80	3,298,172.20	73.00%
2.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,076,300.00	51,984,650.00	14,091,650.00	79.00%
2.1.3.1	Гэрэл, цахилгаан	5,866,300.00	5,866,300.00	0.00	100.00%
2.1.3.2	Түлш, халаалт	58,465,800.00	44,906,400.00	13,559,400.00	77.00%
2.1.3.3	Цэвэр, бохир ус	1,744,200.00	1,211,950.00	532,250.00	69.00%
2.1.4	Хангамж, бараа материалын зардал	9,471,100.00	7,294,528.00	2,176,572.00	77.00%
2.1.4.1	Бичиг хэрэг	3,787,300.00	2,595,900.00	1,191,400.00	69.00%
2.1.4.3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,934,800.00	1,957,128.00	977,672.00	67.00%
2.1.4.5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	215,500.00	208,000.00	7,500.00	97.00%
2.1.4.6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,533,500.00	2,533,500.00	0.00	100.00%
2.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	1,585,600.00	839,000.00	746,600.00	53.00%
2.1.6.1	Багаж, техник, хэрэгсэл	495,000.00	495,000.00	0.00	100.00%
2.1.6.3	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	746,600.00	0.00	746,600.00	0.00%
2.1.6.4	Урсгал засвар	344,000.00	344,000.00	0.00	100.00%
2.1.7	Томилолт, зочны зардал	6,955,000.00	2,210,000.00	4,745,000.00	32.00%
2.1.7.2	Дотоод албан томилолт	6,955,000.00	2,210,000.00	4,745,000.00	32.00%
2.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,616,900.00	9,724,807.00	4,892,093.00	67.00%
2.1.8.1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	400,000.00	0.00	400,000.00	0.00%

	үйлчилгээний төлбөр хураамж				
2.1.8.2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,515,500.00	0.00	3,515,500.00	0.00%
2.1.8.3	Даатгалын үйлчилгээ	705,100.00	449,100.00	256,000.00	64.00%
2.1.8.4	Тээврийн хэрэгслийн татвар	71,700.00	32,382.00	39,318.00	45.00%
2.1.8.6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.00%
2.1.8.7	Газрын төлбөр	49,300.00	23,625.00	25,675.00	48.00%
2.1.8.8	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	875,300.00	219,700.00	655,600.00	25.00%
2.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	430,000.00	430,000.00	0.00	100.00%
2.1.9.2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	430,000.00	430,000.00	0.00	100.00%
5	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,307,500.00	41,281,146.13	26,353.87	100.00%
5.2	Бусад урсгал шилжүүлэг	41,307,500.00	41,281,146.13	26,353.87	100.00%
5.2.3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,697,000.00	1,696,000.00	1,000.00	100.00%
5.2.6	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,135,400.00	31,110,046.13	25,353.87	100.00%
5.2.7	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,475,100.00	8,475,100.00	0.00	100.00%
8	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	828,319,200.00	670,987,985.96	157,331,214.04	81.00%
8.1	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	828,319,200.00	670,987,985.96	157,331,214.04	81.00%
8.1.1	Улсын төсвөөс санхүүжих	828,319,200.00	670,987,985.96	157,331,214.04	81.00%
9.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00%
9.1.1	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00%
9.2	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	0.00	100.00%
9.2.1	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.00%
9.2.2	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00%
9.2.3	Үйлчлэх ажилтан	0.00	0.00	0.00	0.00%
9.2.4	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,657,529.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,657,529.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,657,529.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,444,667.2
210102	Нэмэгдэл	45,444,667.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,212,862.03
210201	Тэтгэврийн даатгал	3,501,375.6
210202	Тэтгэмжийн даатгал	454,446.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	227,223.36
210204	Ажилгүйдлийн даатгал	205,963.29
210205	Эрүүл мэндийн даатгал	823,853.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,270.77
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	132,270.77
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	132,270.77
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,789,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,789,800.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,789,800.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар:

Тус байгууллагад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 6 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 2,700.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 2,700.1 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнээгүй, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай уялдуулан олгоогүй, хавтгайруулан 10,469.0 мянган төгрөг олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэх, гүйцэтгэл, үр дүнд уялдуулан, хэмнэлттэй, үр ашигтай байдлаар тооцож олгох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.2.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

3.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4. Аудитаар нийт 1,141.8 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,141.8 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Татварын тайланд 1 албан хаагчийн 338.6 мянган төгрөгийн цалин тайлагнаагүй, суутгавал зохих албан татварыг 803.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.6-д “бүх зардал”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Аудитаар нийт 8,683.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,683.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн байна.

4.1 Төлбөрийн акт

Байхгүй

4.2 Албан шаардлага

4.2.1 Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомж, зааврын дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй, тооллогын бүртгэл хөтлөөгүй, өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн асуудлыг хэлэлцсэн талаарх тэмдэглэл байхгүй /эд хөрөнгө хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн шинж чанар байдал тодорхойгүй/ байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар” 8. Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, НХМаягт БМ-8, НДЕГ-ын даргын 2022 оны А/64 дүгээр тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллагын НБББББ-ийн 4.5 Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим”-ыг тус тус зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тооллогын бүртгэл хөтлөх, баримтжуулах, баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.2.2 Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 9 албан хаагчид нийт 8,683.4 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон, тушаалд илүү цаг олгох заалтыг тодорхой тусгаагүй /Тухайлбал, 1, 3 дугаар сард нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөөгүй, 4, 6 дугаар сард нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсанд зайлшгүй илүү цагаар ажилласан шалтгаан тайлбар, үндэслэл, ажилласан огноо, цаг минутыг тодорхой бичээгүй /

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 1.4-д “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно”, 3.1-д “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангах, гүйцэтгэл, үр дүнд уялдуулан олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Нийгмийн даатгалын газар	5	3.8	2	1.1	3	2.7	5	3.8				
Дүн	5	3.8	2	1.1	3	2.7	5	3.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын газар	2	8.7			2	8.7						
Дүн	2	8.7			2	8.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийгмийн даатгалын газар								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийгмийн даатгалын газар	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0
Нийт дүн	1	0.0					1	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			